



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар A/31

Өмнөдэлгэр сум

Дэмжлэгийн багийг шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтын 3.2, Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайдын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалын 3.5.1 дүгээр заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/184 дүгээр тушаалын хавсралтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хамран сургах тойргийн хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицоход туслах, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшихэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх тэдний хөгжлийн онцлог, давуу тал, сурч боловсрох, хөгжих хэрэгцээний судалгаа хийх, багш, эцэг, эх, асран хамгаалагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах чиг үүрэг бүхий сургуулийн Дэмжлэгийн багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дэмжлэгийн багийн ахлагч: Ж.Наранцацрал (Сургалтын менежер)

Гишүүд: Д.Шижиртуяа (Нийгмийн ажилтан)

Л.Шинэцэцэг (Сургуулийн эмч)

Д.Отгонжаргал (НУЗАН-ийн ахлагч)

Г.Уянга (БУЗАН-ийн ахлагч)

Б.Мягмарсүрэн (Бага ангийн багш)

Д.Болортунгалаг (МХБУЗ багш)

Г.Мөнхтунгалаг (Мэдээлэлзүйн багш)

Б.Саранчимэг (Эцэг эхийн төлөөлөл)

2.Хамран сургах тойргийн хүүхдийн боловсролын ялгаатай хэрэгцээг тодорхойлох, дасан зохицоход дэмжлэг үзүүлж, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, засан сайжруулах, зөвлөгөө өгөх, багш, эцэг, эх, асран хамгаалагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн дэмжлэг үзүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг дэмжлэгийн багт үүрэг даалгасугай.

3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд тэгш хамруулах ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж үр дүнг улирал бүрийн 20-ны дотор тайлагнаж ажиллахыг Дэмжлэгийн багийн ахлагчид үүрэг болгосугай.

4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын үйл ажиллагаанд зориулсан болон “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-д шаардлагатай сурах бичиг, гарын авлага, сургалтын тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүнийг худалдан авах, орчны стандартыг хангахад шаардлагатай зардлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зарцуулахыг нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан захирлын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА

